- Төрийн үйлчилгээг сумынхаа ард иргэдэд ил тод шуурхай хүргэх, амьдрах орчныг сайжруулах, аж амьдралыг дээшлүүлэх, мал аж ахуйг эрчимжүүлэх, залуу малчдыг малжуулах гэсэн олон талт үйл ажиллагаа явуулах

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Дөргөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Ховд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүү, дотоод аудитын албанаас 2020 онд Дөргөн сумын ТТЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй 2021 оны 02 дугаар сараас эхлэн 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийгдсэн байна.

Дөргөн сумын ТТЗ-ын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшнийг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Энэ нь материаллаг байдлыг үнэ цэнэ талаас нь авч үзэхийн тулд санхүүгийн тайлангийн хамгийн чухал хэсгүүд болох нийт орлогыг /өөрийн орлого, төсвийн санхүүжилт, татвар болон татварын бус орлого / сонгон авч үзлээ.

Төлөвлөлтийн үе шатанд 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангаас тооцсон бол гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн нийт орлого 3660513.4 мянган төгрөгөөр 1 хувиар тооцож 36605.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 78876.9 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 83193.1 мянган төгрөг болж, 4316.2 мянган төгрөгөөр өсөж, төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл		/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь	
ОНХС	21,200.9	39,535.9	18,335.0	1.9	
СХС	37,316.2	162.2	(37,154.0)	(99.6)	
Төрийн сан	20,359.8	43,495.1	23,135.3	213.6	
Дүн	78,876.9	83,193.1	4,316.3	105.5	

Эх сурвалж: Дөргөн сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.2 Авлага

Авлага хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 222487.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 267273.5 мянган төгрөг болж, 44786.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл		/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	
Ажиллагчидтай холбогдсон авлага	267.0	44.3	(222.7)	
Байгууллагаас авах авлага	9,791.3	908.3	(8,883.0)	
Хувь хүмүүсээс авах авлага	4,338.2	2,802.6	(1,535.6)	
Зээлийн хүүгийн авлага	208,090.9	257,167.3	49,076.3	

Татаас санхүүжилтийн авлага		6,351.0	6,351.0
Дүн	222,487.4	267,273.5	44,786.1

Эх сурвалж: Дөргөн сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 219101.3 мянган төгрөгийн дараах авлага байна.

Нийт авлагын дийлэнхийг сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн авлага эзэлж байгаа бөгөөд оны эхэнд 208090.9 мянган төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 38066.0 мянган төгрөгийн зээл олгож, 1012.0 мянган төгрөгийн зээл, зээлийн хүү эргэн төлөгдөж, өмнөх онд зээлийн хүү, алданги 12022.3 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн тэй холбоотой залруулга хийгдэж, оны эцэст 257273.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Сум хөгжүүлэх сангаас 2011-2018 онуудад олгосон 16 зээлдэгчтэй холбогдох 83259.3 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлага байгаа нь сангийн эргэцийг удаашруулж, хөрөнгийн үр өгөөжийг бууруулж, 4 зээлдэгч нас барсан, хугацаа хэтэрсэн 14 зээлдэгчтэй холбогдох авлагыг 2018 онд шүүх, хяналтын байгууллагад шилжүүлж ажилласан байна.

Хүснэгт № 3. Урьдчилгаа дансны үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	30,816.0	-	(30,816.0)
Тусгай зориулалтын сан	92,199.3	87,299.3	(4,900.0)
Цалингийн урьдчилгаа	600.0	600.0	-
Дүн	123,615.3	87,899.3	

Эх сурвалж: Дөргөн сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа данс өмнөх оноос 30816.0 мянган төгрөгөөр буурч оны эцэст 600.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй барагдуулах боломжтой авлага байна.

Аудитын илрүүлэлт:

- 2015 онд жишиг хашаа хөтөлбөрийн хүрээнд 39 иргэнд 28000.0 мянган төгрөгийг олгогдож авлагаар бүртгэсэн, тайлант оны эцэст 26999.3 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй зөрчил илэрлээ.

3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 154263.9 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 209543.6 мянган төгрөг болж, 55279.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 4. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	8,614.9	30,747.2	22,132.3
Эм боох материал		9,900.0	9,900.0
Бичиг хэргийн материал	1,763.5	3,384.6	1,621.1
Аж ахуйн материал	106,582.5	121,964.5	15,382.0
Сэлбэг хэрэгсэл	-	-	-
Түлш, шатах тослох материал	2,856.0	200.0	(2,656.0)
Барилгын засварын материал	-	-	-
Хүнсний материал	1,124.5	9,774.9	8,650.4
Бусад хангамжийн материал	33,022.4	33,272.4	250.0
Мал амьтад	300.1	300.1	-

Дүн	154,263.9	209,543.6	55,279.7
------------	-----------	-----------	----------

Эх сурвалж: Дэргэн сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл Ерөнхий боловсролын сургууль 25000.4, Хүүхдийн цэцэрлэг 9655.9, Эрүүл мэндийн төв 13298.5, ЗДТГазар 5962.9, ИТХурал 691.4, Соёлын төв 670.6 мянган төгрөгөөр тус тус өссөн нь ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг тайлант онд хүнсний материал нөөцөлсөнтэй холбоотой байна. Тайланд онд 37506.5 мянган төгрөгөөр хандив, үнэ төлбөргүйгээр бараа материал нэмэгдэж 203900.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 6185019.3 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 6625321.7 мянган төгрөг болж, 440302.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	4,287,074.2	4,425,634.1	138,559.9
Тээврийн хэрэгсэл	303,909.2	303,909.2	-
Машин тоног төхөөрөмж	518,036.1	658,420.7	140,384.6
Тавилга эд хогшил	343,752.1	364,167.3	20,415.2
Зам гүүрийн байгууламж	53,578.4	53,578.4	-
Түүх соёлын дурсгалт зүйл	5,967.0	5,967.0	-
Дуусаагүй барилга байгууламж	34,370.0	34,370.0	-
Номын фонд	33,441.6	36,726.4	3,284.8
Бусад үндсэн хөрөнгө	479,347.5	617,005.4	137,657.9
Программ хангамж	5,687.0	5,687.0	-
Бусад биет бус хөрөнгө	119,856.3	119,856.3	-
Дүн	6,185,019.3	6,625,321.7	440,302.4

Эх сурвалж: Дэргэн сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвөөс 4510.8 мянган төгрөгийн бэлтгэсэн, үнэ төлбөргүй хандиваар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, Хөшөөт хөгжлийн сангийн хөрөнгөөр 435791.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 13479.3 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 7300.0 мянган төгрөг болж, 6179.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Богино хугацаат өр төлбөр дүн			
Ажилчидтай холбогдсон өглөг	2,784.4	1,132.1	(1,652.4)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	50.0	76.8	26.8
Татаас санхүүжилтийн өглөг		2,541.0	2,541.0
Байгууллагад төлөх өглөг	10,195.0	2,613.0	(7,582.0)
Татварын өглөг	355.5	-	(355.5)
НДШ-ийн өглөг	57.2	-	(57.2)
Хувь хүмүүст төлөх өглөг	37.2	937.2	900.0
Нийт дүн	13,479.3	7,300.0	(6,179.3)

Эх сурвалж: Дэргэн сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд байгаа өглөгүүд 2021 оны тайлангийн хугацаанд бүрэн барагдах боломжтой байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 5643656.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 5760074.3 мянган төгрөг болж, 116418.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7. Засгийн газрын хувь оролцоо		/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/	
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,103,139.8	2,103,139.8	-	
Хуримтлагдсан үр дүн	1,991,233.7	2,107,651.9	116,418.2	
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,549,282.6	1,549,282.6	-	
Дүн	5,643,656.1	5,760,074.3	116,418.2	

Эх сурвалж: Дөргөн сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл өөрчлөлт ороогүй, хуримтлагдсан үр дүн 2107651.9 мянган төгрөг болж 116418.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 104182.2 мянган төгрөгийн ашигтай ажиллаж, бодлогын өөрчлөлт алдааны залруулга дансанд СХС-ийн алданги, хүүг өмнөх онд зөрүүтэй тооцсоноос шалтгаалан бүртгэгдсэн 12022.3 мянган төгрөгийн алдааны залруулга байна.

3.5.10 Орлогын данс

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар татварын орлого 25007.2, тусгай шилжүүлгийн санхүүжилт 211597.7, орон нутгаас олгох санхүүжилт 145047.7, аймгаас олгох санхүүгийн дэмжлэг 78627.6, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого 2357.8, аймгаас олгох санхүүгийн дэмжлэг 151987.7, ЭМДСангаас 2022.2 мянган төгрөгөөр өссөн татварын бус орлого 12492.3, орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих орлого 16202.5, урьд оны үлдэгдлээс санхүүжих 8429.1, үнэ төлбөргүй орлого 1009417.9, нэмэлт санхүүжилтийн орлого 54010.9 мянган төгрөгөөр тус тус буурчээ.

Хүснэгт № 8. Нийт орлогын гүйцэтгэл		/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,223,045.8	3,660,513.4	(562,532.4)	
Татварын орлого	37,084.0	62,091.2	25,007.2	
Татварын бус орлого	14,632.3	2,140.0	(12,492.3)	
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,441,925.6	432,507.7	(1,009,417.9)	
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,550,513.7	1,762,111.4	211,597.7	
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	473,025.7	618,073.4	145,047.7	
Нэмэлт санхүүжилтийн орлого	120,697.4	66,686.5	(54,010.9)	
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	125,914.8	109,712.3	(16,202.5)	
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	8,429.1		(8,429.1)	
Орон нутгийн төсөвт байгууллага төвлөрүүлэх шилжүүлэг		2,357.8	2,357.8	
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	434,875.9	586,863.6	151,987.7	
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	15947.3	17969.5	2,022.2	

Аудитын илрүүлэлт:

- Сумын орлого бүрдүүлэхэд ИТХ-ын тогтоолоор хог хаягдлын үйлчилгээний хураамж, байгалийн ургамлын төлбөр хураамжийн орлого бүрдүүлэх талаар гаргасан тогтоол шийдвэргүй,
- Газрын төлбөрийн хураамжийн орлогыг бодитой төлөвлөөгүй, орлогын төлөвлөгөө биелэх боломжийг бүрдүүлээгүй, татварын байцаагч татварын цахим мэдээллийн санд ногдуулалтыг оруулж өгөөгүй зэрэг зөрчил байна.

3.5.11 Зардлын данс

Нийт зардал өмнөх оноос 490570.3 мянган төгрөгөөр буюу 17.6 хувиар өссөн нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, шимтгэлийн зардал, хангамж, бараа материалын зардал, урсгал шилжүүлэг, хөрөнгийн зардлууд тус тус өссөн, байр ашиглалттай холбоотой урсгал шилжүүлэг, нормативт зардал, томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардлууд буурсан байна.

Хүснэгт № 9 . Зарлагын гүйцэтгэл

/мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт
	2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,787,093.6	3,277,663.9	490,570.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,241,328.9	1,443,665.0	202,336.1
2102	Ажил олгогчоос даатгалд төлөх	161,297.6	181,512.8	20,215.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	90,657.3	84,213.8	(6,443.5)
2104	Хангамж, бараа материалын зардал	45,838.7	55,458.2	9,619.5
2105	Нормативт зардал	101,640.2	44,649.4	(56,990.8)
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,568.2	7,712.8	144.6
2107	Томилолт, зочны зардал	10,847.2	2,686.6	(8,160.6)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	38,482.4	26,502.3	(11,980.1)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	356,463.7	323,571.5	(32,892.2)
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	635,749.6	956,109.0	320,359.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	97,219.8	151,582.5	54,362.7

Аудитын илрүүлэлт:

- ЗДТГазар болон Эрүүл мэндийн төвийн 15277.7 мянган төгрөгийн зарлагын ажил гүйлгээг эдийн засгийн ангилал зөрчин гаргасан зөрчил илэрлээ.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Дөргөн сумын ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөв батлах тухай 8/07 дугаар тогтоолд Дөргөн сумын Төвлөрүүлэн захирагчийн тайлант онд 39319.0 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 61991.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 57.8 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 10 . Сумын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Орлогын ангилал	2020 оны		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	

	39,319.00	61,991.19	(22,672.19)
Нийт орлого ба тусламжийн дүн	39,319.00	61,991.19	(22,672.19)
Татварын орлого	39,319.00	61,991.19	(22,672.19)
Орлогын албан татвар	15,700.00	34,611.25	(18,911.25)
Хувь хүний орлогын албан татвар	15,700.00	34,611.25	(18,911.25)
Үйл ажиллагааны орлого	1,000.00	4,064.80	(3,064.80)
Шууд бус орлого	14,700.00	30,546.45	(15,846.45)
Хөрөнгийн албан татвар	18,424.00	22,371.79	(3,947.79)
Бууны албан татвар	924.00	900.00	24.00
Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого	17,500.00	21,471.79	(3,971.79)
Бусад татвар, телбер, хураамж	5,195.00	5,008.14	186.86
Бусад нийтлэг телбер, хураамж	3,525.00	2,089.93	1,435.07
Улсын тэмдэгтийн хураамж	1,960.00	824.43	1,135.57
Тігээмэл тархацтай ашигт малтмал ашигласны	500.00	400.00	100.00
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1,065.00	865.50	199.50
Газрын телбер		1,534.91	(1,534.91)
Газрын телбер	-	1,534.91	(1,534.91)
Байгалийн нөөц ашигласны телбер	1,670.00	1,383.30	286.70
Ан амьтны нөөц ашигласны телбер		1.50	(1.50)
Ус, рашааны нөөц ашигласны телбер	1,070.00	1,000.00	70.00
Байгалийн ургамлын нөөц ашигласны телбер	600.00	381.80	218.20

Эх сурвалж: Дөргөн сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2724193.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2724193.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 119509.1 мянган төгрөгөөр бууруулж 2604684.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрт зориулан 2604684.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2480502.2 мянган төгрөгийг урсгал зардалд, 124182.3 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1762111.4 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих, 747909.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 51905.0 төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлого, 21200.0 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр тусгай шилжүүлгээс 1731191.1, орон нутгаас 704228.0, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 1905.0, туслах үйл ажиллагааны орлого 1047.0, өмнө оны авлагаас 4900.0, урьд оны үлдэгдлээс 21200.0 мянган төгрөг нийт

Дөргөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2482441.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, орон нутгийн төсөвт 9571.4, аймгийн төсөвт 30057.3 бүгд 39628.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №.11. Санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/д	Байгууллагын нэр	Нийт төлөвлөгөө			Гүйцэтгэл			Зөрүү	Тайлбар
		Санхүүжилт	Өөрийн орлого	нийт	Санхүүжилт	өөрийн орлого	Нийт		
1	ЗДТГ	354,773.3	605.0	355,378.3	353,487.5	605.0	354,092.5	(1,285.8)	
2	ИТХ	51,073.1	-	51,073.1	50,816.1	-	50,816.1	(257.0)	татан төвлөрүүлсэн
3	Сум хөгжүүлэх сан		50,000.0	50,000.0		1,012.0	1,012.0	(48,988.0)	СХС зээл, зээлийн хүүгийн орлого бүрдээгүй
4	ОНХС	100,482.3	23,700.0	124,182.3	100,482.3	4,935.0	105,417.3	(18,765.0)	Төлөвлөгдсөн төсөл хөтөлбөрийн зардал санхүүжүүлээгүйтэй холбоотой мөнгө үлдсэн
ОНБ-дын дүн		506,328.7	74,305.0	580,633.7	504,785.9	6,552.0	511,337.9	(69,295.8)	
5	ЕБСургууль	1,108,499.4	300.0	1,108,799.4	1,070,465.9	300.0	1,070,765.9	(38,033.5)	татан төвлөрүүлсэн
6	Хүүхдийн цэцэрлэг	440,918.8	-	440,918.8	431,299.2	-	431,299.2	(9,619.6)	татан төвлөрүүлсэн
7	Эрүүл мэндийн төв	383,682.5		383,682.5	379,231.1		379,231.1	(4,451.4)	ЭМД-ын сангаас авах санхүүжилтийг бүрэн авч чадаагүй
8	Соёлын төв	89,650.1	1,000.0	90,650.1	88,806.9	1,000.0	89,806.9	(843.2)	Ковид-19 цар тахалтай холбоотой үндсэн үйл ажиллагааны орлого бүрдээгүй, 818.2 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн
ТЗШ дүн		2,022,750.8	1,300.0	2,024,050.8	1,969,803.1	1,300.0	1,971,103.1	(52,947.7)	
Нийт дүн		2,529,079.5	75,605.0	2,604,684.5	2,474,589.0	7,852.0	2,482,441.0	(122,243.5)	

Үндсэн үйл ажиллагааны орлого 2952.0 мянган төгрөгөөр бүрдүүлж, батлагдсан төсвөөс 48953.0 мянган төгрөгөөр тасарсан нь СХС-гийн зээлийн эргэн төлөлтөөс бүрдүүлэх орлогыг бүрэн төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын 18 төсөл, арга хэмжээнд 124182.3 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас 87082.3 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн хөгжлийн сангийн дансанд 39535.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2501260.0 мянган төгрөг нь 96 хувьтай байгаа нь сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн төлөвлөгөө тасарсантай холбоотой байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Онцгой байдлаас Ковид-19 цар тахлын зардал, статистикийн судалгааны зардал, Онцгой байдлаас томилолтын зардал, сурах бичгийн түрээсийн орлогоор нэмэлт орлогын дансанд 77771.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, орон нутгийн төсөвт 6351.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №12. Нэмэлт данс /мянган төгрөг/

	Бусад орлого	Нийт	
1	ЗДТГ	59,096.8	ОНХС хөрөнгө оруулалт, статистикийн судалгааны зардал
2	ЕБСургууль	6,159.1	Түрээсийн номын орлого, урьд оны авлага
3	ИТХ	500.0	Аймгийн ИТХ-аас шагнал
4	Соёл	213.2	БСГ-аас олгосон шагнал

5	ЭМТ	11,802.9	11,802.9	ЭМГ -аас эм эмнэлгийн хэрэгслийн үнэ, сорьц тээвэрлэлтийн зардал, ковидын зардал
Нийт дүн		77,771.9	77,771.9	

Үүнээс үндсэн цалин, шимтгэлд, хангамж бараа материалын зардал, эм эмнэлгийн хэрэгсэл авах зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, бусад бараа үйлчилгээний зардалд зарцуулсан байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 151 мэдээллээс 144 мэдээллийг хугацаанд нь, 89 мэдээллийг хугацаа хоцроож, оруулах хугацаа болоогүй 2 мэдээлэл, дараа жилийн төсвийн төслийн мэдээллийг байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 1 төлбөрийн акт бичигдэж бүрэн барагдуулж, албан шаардлага өгөгдөөгүй, 72127.0 мянган төгрөгийн 4 алдаа зөрчилд зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт 82 хувьтай хэрэгжсэн байна.

Хүснэгт 13. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	3,168.8	1	3,168.8	1	3,168.8	100%
Зөвлөмж	4	72,127.0	4	72,127.0	3	59,214.0	82%
Нийт	5	75,295.8	5	75,295.8	4	62,382.8	

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 4 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 7 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагыг аудитад хамруулан дүгнэлт гаргаж, 3 тайланг түүвэрт хамруулсан байна.

Хүснэгт №14. Аудитад хамрагдсан хэлбэр, аудитын дүгнэлт

№	Байгууллагын ангилал, нэр	Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр			Аудитын дүгнэлт	
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт	Гэрээгээр хийлгэсэн	Зөрчилгүй	хязгаарлалттай
1	Төсвийн шууд захирагч	ЗДТГ	1			1
2		ИТХ		1		
3		Сургууль	1			1
4		Цэцэрлэг	1			1
5		Соёлын төв	1		1	1
6		ЭМТөв	1			1
7	ОНТС	СХС		1		
8		ОНХС		1		
Дүн		5	3	1	3	2

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”-3, “Хязгаарлалттай” 2, нийт 5 дүгнэлт гаргасан байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар илэрсэн алдаа, зөрчил:

Аудитаар нийт 86142.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2331.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 83811.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өглөө.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- СХС-ийн санхүүгийн үр дүнгийн тайланд орлого илүү, тайлант үеийн үр дүнг 2024.0 мянган төгрөгөөр зөрүүтэй,
- ИТХурал өглөг, тайлант үеийн үр дүнг 307.2 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлснийг залруулга хийсэн.

Төвлөрүүлсэн захирагчид 83811.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 6 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Хүснэгт № 15. ТТЗ-ийн тайланд илэрсэн алдаа / мянган төгрөг/

нийт илэрсэн алдаа										Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт
№	Байгууллагын ангилал, нэр	нийт илэрсэн алдаа		Үүнээс залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж		
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	
1	ТТЗ	4	42,277.0			4	42,277.0	4	42,277.0	
2	ОНТС	СХС	2	2,024.0	2	2,024.0				
3		ОНХС	1	40,600.0			1	40,600.0	1	40,600.0
		ИТХ	3	1,241.9	2	307.2	1	934.7	1	934.7
	Дүн		10	86,142.9	4	2,331.2	6	83,811.7	6	83,811.7

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн алдаа, зөрчил

Дөргөн сумын ТТЗ-ын нэгтгэлд хамрагдсан төсвийн шууд захирагчдын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 300397.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, 195171.5 мянган төгрөгийн алдааг залруулсан байна.

Залруулагдаагүй 105225.6 мянган төгрөгийн алдаа зөрчлөөс 227.1 мянган төгрөгийн 1 алдаа зөрчилд төлбөрийн акт, 79970.4 мянган төгрөгийн 4 алдаа зөрчилд албан шаардлага, 105225.6 мянган төгрөгийн 12 алдаа зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна. Нийт алдаа зөрчил, шийдвэрлэлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 16. ТШЗ-ын нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн нийт алдаа зөрчил, шийдвэрлэлт /мянган.төгрөг/

№	Байгууллагын ангилал, нэр	нийт илэрсэн алдаа		Үүнээс залруулсан		Залруулаагүй		
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	
1	Төсвийн шууд захирагч	ЗДТГ	6	160,928.3	4	107,833.7	2	53,094.6
2		ИТХ	-	-				
3		Сургууль	4	85,710.5	2	80,766.2	2	4,944.3
4		Цэцэрлэг	2	-			2	
5		ЭМТөв	10	52,145.4	3	5,185.8	7	46,959.6
6		Соёлын төв	3	1,612.9	1	1,385.8	2	227.1
	Дүн		25	300,397.1	10	195,171.5	15	105,225.6

№	Байгууллагын ангилал, нэр	Залруулаагүй алдаа, зөрчил		Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт					
		тоо	дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	ЗДТГ	2	53,094.6	-	-	3	53,094.6		
2	ИТХ	0	-	-	-	-	-	1	934.7
3	Төсвийн шууд захирагч Сургууль	2	4,944.3					2	4,944.3
4	Цэцэрлэг	2	-					2	
	ЭМТөв	7	46,959.6			1	26,875.8	6	20,083.8
5	Соёлын төв	2	227.1	1	227.1			1	
	Дүн	15	105,225.6	1	227.1	4	79,970.4	12	25,962.8

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Сумын орлого бүрдүүлэхэд ИТХ-ын тогтоолоор хог хаягдлын үйлчилгээний хураамж, байгалийн ургамлын төлбөр хураамжийн орлого бүрдүүлэх талаар гаргасан тогтоол шийдвэргүй, газрын төлбөрийн хураамжийн орлогыг бодитой төлөвлөөгүй, орлогын төлөвлөгөө биелэх боломжийг бүрдүүлээгүй, татварын байцаагч татварын цахим мэдээллийн санд ногдуулалтыг бүрэн оруулаагүй зөрчил илэрлээ.

1.2. Эрсдэл: Орлого дутуу батлах, төсвийг бодитой бус төлөвлөх, орлого бүрэн бүрдүүлээгүй байх

1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн "төсвийн төсөл боловсруулахад тавигдах шаардлага", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг мөрдөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна", Сангийн сайдын 388 дугаар тушаалаар "төсөвт байгууллагад мөрдөх НББ-ийн дансны заавар"-ын 4.76-д "Орлого, зарлагын нэгдсэн дансны зөрүүгээр тайлангийн үеийн үр дүнг тодорхойлно"

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

2.1 . ОНХСангийн зарцуулалттай холбоотой асуудал

2.1.1. Илрүүлэлт: ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэж ажилд урьдчилгаа санхүүжилтийг өндөр дүнгээр олгодог, ажлын гүйцэтгэл, явцын мэдээг хянасан талаар анхан шатны баримт дутуу зэрэгт 30600.0 мянган төгрөгийг олгосон, ИТХ-ийн төлөөлөгчдийг чадавхжуулах хөтөлбөр арга хэмжээ хэрэгжүүлэхэд 4000.0 мянган төгрөгийг зарцуулсан, ТЭЗҮ, зураг төсөв, захиалагчийн хяналтын зардал, чанарын баталгаат барьцааны тооцоог хийгээгүй зэрэг зөрчил дутагдал илэрлээ.

2.1.2. Эрсдэл: Сангийн хөрөнгийн үр өгөөж буурах, төсөвт зураг төсвийн өр үүсэх, холбогдох хууль дүрэм журам хэрэгжихгүй байх, санхүүжилтийг өндөр дүнгээр олгох, төсөл арга хэмжээ хэрэгжихгүй байх

2.1.3 Өгсөн зөвлөмж: Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны 228 дугаар журмын 3.1.2-д "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх";, 4.2-д "ОНХС-ийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулж үл болно", 4.2.5-д "Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагаас бусад улсын төсвийн байгууллагын хөрөнгийн зардал";, 4.2-д "ОНХС-ийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулж үл болно", Төсвийн тухай хуулийн 60.4-д "энэ хуулийн 60.3.1-д заасан хуулиар тогтоосон чиг үүрэгт аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг хамаарахгүй" ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхийг хориглоно", гэсэн заалтыг мөрдөх, захиалагч барилгын ажлын зардал ТЭЗҮ, зураг төсвийн үнэ, захиалагчийн хяналтын зардал, чанарын баталгаат хугацааны барьцааг тус тусын дансанд холбогдох баримт, материалыг үндэслэн шилжүүлж, ажлын үр дүнг харгалзан санхүүжилт олгохоор талаар гэрээнд тусгах, зориулалт бус зардлыг төлөвлөхгүй байх,

2.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Үйлчлүүлэгч байгууллага хүлээн зөвшөөрсөн

3.1 . Эд хариуцагчийн тайлан гаргалттай холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт: Тайлант онд сумын ИТХурал 934.7 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан эд хариуцагчийн тайлан гаргаагүй, жолоочийн тооцоо бодоогүй зөрчил илэрлээ.

3.1.2. Эрсдэл: Эд хариуцагчийн тайлан гаргаагүй байх, жолоочийн тооцоо бодоогүй байх,

3.1.3 Өгсөн зөвлөмж: Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 15-д Хариуцаж байгаа эд зүйлийг зохих хууль ёсны баримт материал бүрдсэн буюу удирдлагын шийдвэрээр зориулагдсан зүйлд нь өөрийн биеэр тавьж олгож, хяналт тавьж ажиллана, Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 17-д Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдээдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид өгч байна" гэсэн заалтыг мөрдөн эд хариуцагчийн тайлан гарган, жолоочийн тооцоог бодох, зарцуулалтад хяналт тавин ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Үйлчлүүлэгч байгууллага хүлээн зөвшөөрсөн

4.1 . Авлагын данстай холбоотой асуудал

4.1.1. Илрүүлэлт: 2015 онд жишиг хашаа хөтөлбөрийн хүрээнд 39 иргэнд 28000.0 мянган төгрөгийг олгогдож авлагаар бүртгэсэн, тайлант оны эцэст 26999.3 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй зөрчил илэрлээ.

4.1.2. Эрсдэл: Авлага барагдуулаагүй байх,

4.1.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасны дагуу дээрх авлагыг барагдуулан ажиллах

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Үйлчлүүлэгч байгууллага хүлээн зөвшөөрсөн

5.1 .Зардлын данстай холбоотой асуудал

5.1.1 Илрүүлэлт: ЗДТГазар, Эрүүл мэндийн төвүүд 2020 онд 15277.7 мянган төгрөгийн зарлагын ажил гүйлгээг эдийн засгийн ангилал зөрчин зардал гаргасан зөрчил илэрлээ.

5.1.2. Эрсдэл: Эдийн засгийн ангилал зөрчсөн байх, бүлэг хооронд шилжүүлэх зөвшөөрөл аваагүй байх

5.1.3 Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 73 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт 4.1.7-д "Төсвийн тухай хуулийн 42.4-т заасны дагуу дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг авсан байх", Төсвийн тухай хуулийн 42.4-д "энэ хуулийн 42.2-т заасан төсвийн зохицуулалтыг хийхэд дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг авна" ,

42.2-т "ТТЗахирагч нь түүнд хамаарах төсвийн шууд захирагчийн төсөв хооронд" гэсэн заалттай нийцүүлэн бүлэг хооронд шилжүүлэх шийдвэр гаргуулах, Төсвийн захирагчийн төсөвт зохицуулах журмыг мөрдөн ажиллах

5.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Үйлчлүүлэгч байгууллага хүлээн зөвшөөрсөн

6.1 . Шилэн дансны тухай хуультай холбоотой асуудал

6.1.1 Шилэн дансны тухай хуульд заасны дагуу shilendans.gov.mn цахим сайтад 95 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, дараа жилийн төсвийн төслийн мэдээллийг байршуулаагүй дутагдал байна.

5.1.2. Эрсдэл: Хуульд заасан мэдээллийг хугацаанд мэдээлээгүй байх,

5.1.3 Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоолын 4.1.15-д "орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлийг арга хэмжээ тус бүрээр сар бүрийн 8-ны дотор, энэхүү журмын 11 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар PDF, EXCEL, XML форматаар;" Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-д "дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор;" бусад заалтуудыг мөрдөн холбогдох мэдээллийг хугацаанд мэдээлж хэвших

5.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Үйлчлүүлэгч байгууллага хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 6 дугаар сарын 15-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье. Хавсралт

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020	Аудитын нэр:	Дөргөн сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан	Аудитын код: ХОА-2021/09/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Дөргөн сумын Засаг дарга		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	СХС-ийн санхүүгийн үр дүнгийн тайланд орлого илүү, тайлант оны үр дүнг зөрүүтэй илэрхийлсэн	2024.0	Залруулга хийх	Засаг дарга, нягтлан бодогч	Л.Цэдэн- Иш Б.Ган-Очир
2	ИТХ-ын санхүүгийн тайланд өглөг, тайлант үеийн үр дүнг зөрүүтэй тусгасан	307.2	Залруулга хийх	ИТХ-ын нарийн бичгийн дарга, нягтлан бодогч	М.Азжаргал Б.Бадамгарав
3	ИТХурал тайлант онд худалдан авсан шатахууны тайлан гаргаагүй, тооцоо бодоогүй	934.7	Зөвлөмж өгөх	ИТХ-ын нарийн бичгийн дарга, нягтлан бодогч	М.Азжаргал Б.Бадамгарав

4	Эдийн засгийн ангилал зөрчиж ажил гүйлгээ гаргасан	15277.7	Зөвлөмж өгөх	Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Л.Цэдэн- Иш Т.Хишигмаа
5	ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэж ажилд урьдчилгаа санхүүжилтийг өндөр дүнгээр олгодог, ажлын гүйцэтгэл, явцын мэдээг хянасан талаар анхан шатны баримт дутуу, ИТХ-ийн төлөөлөгчдийг чадавхжуулах хөтөлбөр арга хэмжээ хэрэгжүүлсэн, ТЭЗҮ, зураг төсөв, захиалагчийн хяналтын зардал, чанарын баталгаат барьцааны тооцоог хийгээгүй	40600.0	Зөвлөмж өгөх	Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Л.Цэдэн- Иш Т.Хишигмаа
6	Сумын орлого бүрдүүлэхэд ИТХ-ын тогтоолоор хог хаягдлын үйлчилгээний хураамж, байгалийн ургамлын төлбөр хураамжийн орлого бүрдүүлэх талаар гаргасан тогтоол шийдвэргүй, газрын төлбөрийн хураамжийн орлогыг бодитой төлөвлөөгүй, орлогын төлөвлөгөө биелэх боломжийг бүрдүүлээгүй, татварын байцаагч татварын цахим мэдээллийн санд ногдуулалтыг оруулж өгөөгүй		Зөвлөмж өгөх	Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Л.Цэдэн- Иш Т.Хишигмаа
7	2015 онд жишиг хашаа хөтөлбөрийн хүрээнд 39 иргэнд 28000.0 мянган төгрөгийг олгогдож авлагаар бүртгэсэн, тайлант оны эцэст 26999.3 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй	26999.3	Зөвлөмж өгөх	Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Л.Цэдэн- Иш Т.Хишигмаа
8	Шилэн дансны тухай хуульд заасны дагуу shilendans.gov.mn цахим сайтад 95 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, дараа жилийн төсвийн төслийн мэдээллийг байршуулаагүй дутагдал байна.		Зөвлөмж өгөх	Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Л.Цэдэн- Иш Т.Хишигмаа
	Дүн	86142.9			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР